

**“ЖАНГАР” ТУУЛИЙН БААТРУУД БА
БУДДЫН ШАШНЫ АРВАН ХАНГАЛ**

Г.Нандинбилиг

Түлхүүр үг: *Жангар тууль, халх хувилбар, туульсын баатрууд, Бурханы шашин, Арван хангал бурхад*

Жангарын туулийн халимаг, ойрад, халх, буриад олон хувилбаруудаас халх Жангарын хувилбаруудын онцлог ялгаа нь бурхны шашны нөлөө их туссан байдагтаа оршино. Халхчуудын хувьд олон сүм хийд байгуулагдаж, эрэгтэйчүүдийн олонх нь сүмд шавилан лам болцгоож, айл гэр бүр ламтай болсон учир ардын уламжлалт соёлын олон зүйлийг бурхны шашны утга агуулгатай болгож, тийм утга үгүй аваас үнэ цэнгүй хэмээх үзэл санаа ихээхэн дэлгэрчээ. Үүний нэг нь монгол баатарлаг туульсыг бурхны шашны үзэл ойлголт, бурхад дошгидын дүрүүдтэй холбон тайлбарлах оролдлого болно. Энэхүү оролдлого нь нийт монгол угсаатны их туурвил болох Жангарын туульсыг ч гэсэн тойрч гарсангүй. Энэ удаагийн судалгаандаа бид Жангарын туулийн нэгэн өвөрмөц хувилбарын жишээн дээр тулгуурлан, халхчууд Жангарын туулийг хэрхэн шашинжуулсныг дүр, өгүүлэмжийн түвшинд авч үзэхийг зорьсон болно.

Халх Жангарын хувилбаруудаас бурханы шашин гүн нэвтэрсэн талаасаа хамгийн сонирхолтой нь 1997 онд хуучин Сайн ноён хан аймгийн Дашдоо гүний хошууны¹ туслагч тайж явсан Дандардоржийн охин үлгэрч туульч Өлзий гуайгаас бичиж авсан “Богд Жанхар хаан” хувилбарт өгүүлдэг арван хангал, есөн догшдын тухай дурдалга болно. Д.Өлзий гуай энэ хувилбарыг “Үлгэрийн танхимын” жүжигчин агсан Цэрэндэмчиг ламаас сурсан ажээ.

Туульч Д.Өлзий гуай бол халх нутагт үлдэж цөөн эмэгтэй хоцорсон туудчийн нэг Дандардоржийн Норжмаа агсаны төрсөн дүү болно. Д.Норжмаа гуай бол өөрийн нагац ах Жамсранбал тайжаас хэд хэдэн тууль сурч хэлдэг байсан билээ. Жишээлбэл “Жигүүн жигүүн төмөр хаан, жигүүн төмөр цагаан хаан” хэмээх халх туулийг аялгуулан хэлж, өөрийн дүү Өлзийд зааж өгснийг хуурдан хэлдэг билээ. Ийнхүү халх эрчүүдийн олонх нь хүрээ хийдэд сууж, номын мөр хөөсний улмаас язгуур туульчийн уламжлал нь эмэгтэйчүүдийн үйл хэрэг болж үлдсэнээрээ баруун монголчуудаас ялгаатай. Тухайлбал баруун Алтайн урианхайчуудын өнөө хүртэл үлдсэн амьд уламжлалд эмэгтэй хүн тууль хайлахыг хоригдодог билээ. Д.Норжмаа, Д.Өлзий гуай нарын аав, туслагч тайж Дандардорж абугай бол Богд хааны ордонд төрийн дууч шалгаруулах сорилгод оролцож, шар торгон жолоогоор шануулж, “Төрийн дууч” цол хүртэж байсныг үзэхэд энэ тайжийн гэр бүлийнхэн удам судраараа монгол уртын дуу, халх туульсын өвлөн уламжлагчид байсан байна.

“Богд Жанхар хаан” нэртэй тус хувилбарт гарч буй гол үйл явдал нь Богд Жанхар хааны гурван жилийн номын хурих хийх цаг түүх нь болж, гучин хоёр баатардаа зар зурхай хүргэн, сүм дуган хийх сайхан газар нутгийг шинжин олж сүм байгуулсан үйл хэргийг өгүүлэх

¹ Одоогийн Баянхонгор аймгийн Галуут сумын нутаг

өгүүлэх бөгөөд Жангарын баатар бодонгуудыг бурханы шашны домог зүйтэй холбож, арван хангалтайгаа хамт дайснаа дарж, дархан цолоо олж, ар газар шашин төрийг дэлгэрүүлж, амар сайхандаа жаргав гэж төгсдөг. Энэ нь туульсын уламжлалыг шашинжуулж байсны бодит баримт болж байна.

Энэ туулийн нэг гол баатар болох арван буман адууг нь хариулдаг алиа шар дарга алс хол явдаг амьтан хүн таньдаг гэдгээрээ газар шинжээчээр томилогдож байна. Туульсын тус хувилбарт:

*. . . Алиа шар дарга нь
Агсан шар азаргаа унаад
Жилийн газрыг сараар
Сарын газрыг өдрөөр товчлон
Мянган нэртэй далайн захаар
Давхиж явтал азарга нь хэвтээд өгөв гэнэ.
Алиа шар даргын уур нь хүрч
Чи яагаад хэвтчихэв
Тархи руу чинь тавь
Зулай руу чинь зуу
Ташуурдана гэж уурлав гэнэ.
Чамайг мэдээгүй байхад
Би мэдээд хэвтэж байна
Энэ газар сүм дуган бариулбал
Аятай сайхан газар юм гэв ээ
Алиа шар дарга
Агсан шар азаргынхаа
Баруун өвдөгнөөс нь адис аваад
Арван алд шар хадаг уяв гэнээ
Алиа шар дарга
Арван зүгт шинжсин
Арц хүжээ асааж гэнэ*

гэхчлэн өгүүлж байна. Газар шинжих энэхүү ёс заншил бол олон монгол угсаатанд байдаг язгуурын соёл бөгөөд хамгийн ойрын жишээ гэхэд 1921 онд ардын журамт цэрэг Нийслэл хүрээнд орж ирээд, Сүхбаатар жанжин Хүрээний олон ардын дунд үг хэлж байхад түүний ухаа хонгор морины шээсэн газарт өнөөгийн Сүхбаатарын талбайг байгуулж, хөшөөг нь босгосон гэж журамт цэргийн дурсамжуудад гардаг билээ. Энэ мэтчилэн тус хувилбарт монгол язгуур соёлын зарим зүйл хадгалагдан байх боловч хожмын бурхны шашны газар шинжих ёсны нөлөө ч бас байна. Жишээлбэл:

*Буман нэртай далайн захаар
Бурхан шашин дэлгэрч байхаар
Шинжсив гэнэ
Шарлоо нэртэй шашныг
Хүрээлэн байхыг шинжсив гэнэ
Түмэн нэртэй далайн захаар
Төр шашин хоёр
Дэлгэрэн байхыг шинжсив гэнэ
Дөрвөн зүгт шинжсив гэнэ
Дөрвөн ууландаа мөргөв гэнэ
Авч явсан алтан ембүүгээ
Арван хэд хувилгаад
Сүм дуганыхаа*

*Шал довжоог тавьчихаад
Богд Жанхар хаандаа бараалхав гэнэ*

гэж өгүүлэх ба “шарлоо нэртэй шашин” гэдэг нь шарын шашныг хэлж буй бололтой.

Энэ туульсын хамгийн сонирхолтой зүйл бол алия шар даргын сүм хийд барихаар сонгосон газар нь өнөөгийн монгол улсын нийслэл байгаа Ханбогдын ар, хатан туулын хөвөө газар мэтээр гардаг. Тухайлбал

*Богд Жанхар хааны орон нутгийг нь хэлбэл
Хүдэр билгийн хаан ширээ гэдэг нь
Хан Богд байжээ
Мянган нэртэй далайн хаяа гол гэдэг нь
Хатан Туул байжээ
Хүдэр билгийн хаан ширээтийн
Орой дээр дэлдсэн
Луу жинтэй хэнгэрэг гэдэг нь
Гүрмийн хэнгэрэг байжээ*

гэхчлэн өгүүлдэг. Чингэхлээр энэ нь халимаг, ойрад Жангарын туульст гардаг нутаг тогоос Алтай, өргөн шартаг далай биш, хан Богд уулын ар, хатан Туулын хөвөө, төв халхын газар нутаг болж байна.

Цаашилбал бидний олж тэмдэглэсэн “Богд Жанхар хаан” хэмээх хувилбарт Жангарыг баатруудынх нь хамтаар бурхны шашны домог зүйтэй холбох буюу тэдгээр баатруудыг шарын шашны арван хангалтай адилтган, бурханы шашны арван хангалын хувилгаан дүр болгож дүрсэлсэн нь сонирхол татаж байна. Богд Жанхар хааны гучин хоёр баатруудын дотроос арван догшид баатруудыг тус тус хэрхэн адилтгасныг авч үзье. Тухайлбал, Богд Жанхар хааныг буман бурханы бүрэлбаатай гэж өгүүлдэг бол гучин хоёр баатрынх нь тэргүүлэгчийг

*Ар өвөр дэх нь мэдэгдэхгүй
Нэг зуун хорин таван настай
Багш Бигэрмижид
Далай цэцэн баатар гэдэг нь
Жигжид бурхан байжээ*

гэж Энэтхэгийн хашлагат үлгэрийн нэгэн гол баатар Бигэрмижид хааны нэрээр цоллуулсан далай цэцэн баатар нь арван хангал бурхдын эхнийх нь болох шарын шашны үндсэн авралт гол шүтээн Ямандага (Манзушири бурхны догшин дүр) буюу төвдөөр Жигжид, монголоор Аюулган үйлдэгч хэмээх бурхны бүрэлбаа болгосон нь Очирт хөлгөний нууц дандарын ёсны гол шүтээн Ядам сахиус гэгээрэлд хөтлөгчийг сонгосноороо Жангарын бусад хувилбарт байдаг ирээгүй 99 жилийг угтаж, ирсэн 9 жилийг дагаж мэддэг, ухаанаараа бумбын орныг давсан Алтан цээж баавайн халх монгол хувилбар дүр нь болж байна. Тийм ч учраас багш Бигэрмижид далай цэцэн баатар гэж нэрлэсэн байна.

*Гучин хоёр баатрын хоёрдугаарт
Хуучин хурьцсан
Сэлэмт баатар гэдэг нь
Очирваань бурхан байжээ*

хэмээн арван хангал бурхны хоёр дахь нь болох нууц тарнийн ёсны дамжилгыг авч, монгол орны үндэстэн даяарын шүтээн болсон Очирваань бурханыг хэлсэн нь арван хангалын дэс дарааллыг баримтлах гэж оролдсонтой холбоотой байна. Мөн Очирваанийг монгол орны догшин савдгийг дарангуйлах гол үүрэгтэй байсантай нь холбоотойгоор хуучин хурьцсан сэлэмт баатар гэж нэрлэсэн бололтой. Түүнчлэн Хангайн нурууны гол ноён оргил Отгонтэнгэрийг Очирваань гэж цоллосон байдаг билээ.

*Нэг зуун далан таван суурь адуутай
Дамба Далай нэртэй
Давхар хурган дээлтэй
Хар хул хааны хүү
Хазар Гүзэн баатар гэдэг нь
Гомбо бурхан байжээ*

хэмээн өгүүлснээс үзэхэд Жангарын бусад хувилбарт зүүдчээрээ давсан Гүзэн Гүмбэ баатрыг энэ халх хувилбарт Жанрайсаг бурхны хувилгаан, догшин дүр нь болох хиндү шашинтан тэнгэрийн дүрээр бурхны шашинтан арав дахь газрын бодисадбагийн дүрээр их төрөлхтний гэтэлгэгч номын сахиус байдлаар шүтдэг Махагала бурхан болгосон гэсэн үг. Гомбо бол шарын шашны хамгаалагч байгаад монгол оронд эртнээс түгээмэл дэлгэрсэн бөө мөргөлийг дарангуйлах гол үүрэгтэй болж, бүр сүүлдээ бөө нарын шүтээн болж тахигдсан түүхтэй. Мөн Гомбо Махагалыг монгол орны сахиус зургаан мутарт, далан таван нөхөр сэлт бүхий Гомбо бурхнаар монгол оронд эртнээс түгээмэл дэлгэрсэн бөө мөргөлийг дарангуйлах гол үүрэгтэй нь холбоотойгоор “хуучин хурыцсан сэлэмт баатар” гэж цоллосон бололтой байна. Дараа нь:

*Сайхан Гомбын садан сүлбээ
Хун цагаан морьт баатар гэдэг нь
Гонгор бурхан байжээ.*

Арван хангалын нэг Гонгор бурхан нь хүслийг хангагч чандмань эрдэнийг эзэмшигч, эд юмаар элбэг баян, идээ ундаагаар арвин дэлгэр байлгаж, ядуугийн зовлонгоос гэтэлгэх увидастай бурхан бөгөөд нэрийг нь монголоор орчуулбал “Цагаан Махагал” буюу Махагалын цагаан дүр гэгддэг. Сайхан Гомбын садан сүлбээ гэхийн учир нь Гонгор бурхныг Гомбо бурхны зүрхнээс залдагтай холбоотой. Гонгор бурхан нь Гомбо бурхнаас даасан үйлээрээ ялгаатай. Гонгор бурхан нь хүн төрөлхтнийг ховор хоосон, явар ядуугийн зовлонгоос салгахын тулд цагаан дүрээр хувирч, энэ ертөнцөд заларсан гэдэг бөгөөд монгол оронд өнөөг хүртэл Гонгорын бумбаны тахилгыг шинийн 8, 14-нд хийсээр байна. Гонгорын гол нөхөр сэлт нь 5 хандмаа (хөх өнгөт Санжааханд, шар өнгөт Ринчинханд, улаан өнгөт Бадамханд, ногоон өнгөт Лайжханд, цагаан өнгөт Доржханд) нар болно. Түүнчлэн монголын олон хүрээ хийдийн тахилгын үед, Махагал бурхны аравнайлах болоход хаанаас ирсэн нь мэдэгдэхгүй нэг сайхан хүн ирж хадаг өргөөд, гэнэт алга болдгоос сайхан Гомбо гэж нэрийг авсан гэдэг аман домог байдаг.

*Дөрвөн уулыг эзэгнэн суудаг
Соном мэргэн зурхайч баатар гэдэг нь
Чойжоо бурхан байжээ.*

Чойжоо бурхан гэж Дамжинчойжил буюу үйлийн үрийг дэнслэн шүүж, ирээдүйн төрлийг тодорхойлогч Эрлэг номун хааныг хэлсэн байна. Соном мэргэн зурхайч гэхийн учир нь Эрлэгт ирсэн сүнснүүдийн үйлийн үрийг тооцон бодож, заяа зурхайг нь заадаг гэсэн санаа байх шиг байна.

*Орчлонгийн сайхан Мигмияхүү баатар гэдэг нь
Лхам бурхан байжээ.*

хэмээн Жангарын туулийн үзэсгэлэнт баатар болох орчлонгийн сайхан Минъяныг Лхам бурхан болгож хэлжээ. Лхам бурхан бол нийт Төв азийн домог зүйн сан хөмрөгт байдаг соёлт баатар бөгөөд мангасын хааныг дарахын тулд түүний хатан болж очоод, мангасын хааны амин газар мэсэлж хөнөөн зугтаасан домогтой. Тэрээр мангасаас бие давхар болсон тул зам зуураа бие нь чилээрхэж, хонгор халзан луусныхаа хондлойг түшин амарч байхад луус нь хойт хөлөөрөө тангарсан тул Лхам бурхан “Үр төлгүй бол” гэж харааснаас луус үргүй болсон гэдэг домогтой. Луусанд өшиглүүлж гарсан мангасын хүүхэд хэвлийгээс

гарангуутаа эхтэйгээ байлдах гэхэд нь “муугийн үр муу л байх юм” гэж эмээлийнхээ дөрөөгөөр цохиж үхүүлсэн учир тэр цагаас хойш дөрөөгөөр зангахыг цээрлэдэг болжээ. Мөн түүнчлэн Лхам бурхан их ус мөрөн гаталж, хүний омогт нийлэх үед нь цагаан сарын шинийн нэгэн болж байсан тул цагаан сараар монголчууд

-“Мэнд гарав уу?

- Мэнд гарлаа” гэж мэндлэн золгодог болсон гэж өгүүлдэг. Лхам бурхан мангасыг алснаас гар нь цустай байсан болохоор ханцуй буулгаж золгодог болсон домогтой төдийгүй цагаан сарын шинийн нэгэнд Лхам бурхны унааг ундална гэж зөв тогтон дээрээ мөс тавьдаг зашилтай. Энэ хоёр дүрийг адилтгахын учир нь эдгээр дүрүүдийн хар хорыг дарсан арга нь адил байсантай холбоотой бололтой. Лхам бурхан мангасын эхнэр болж очиж мангасыг дарсан бол Миньяан найман хөлтэй аалз болон хувилж очиж, дайснаа дарсан байдаг.

Мөн цаашилбал, тус хувилбарт

Бага нэртэй бадриун чадалтай

Хөх дүрт Базай баатар гэдэг нь

Шаш бурхан байжээ

гэж байна. Энд гарч байгаа Шалши бурхан гэдэг нь Бурхан багшийн мэлмийн өмнө эрдэнэт шашныг сахихаар тангарагласан их хар Шалшийг хэлжээ. Шалши хэмээх нэрийг нь монголоор орчуулбал Дөрвөн нүүрт хэмээх бөгөөд Дэмчиг бурхнаас хувилж гарсан номын сахиус юм. Шалши хэмээх нэрийг халгуу\ташаа дуудлагаар Шаш гэсэн байна. Бадируун чадалт Базай баатар гэж цоллосон нь Жангарын туульдаа Хүнд гарт савар байж болох юм гэж таамаглаж байна.

Агсан шар азаргатай

Алиа шар баатар гэдэг нь

Намсрай бурхан байжээ.

Энэтхэгийн домог зүйн Гувера (муухай царайт) тэнгэр буюу Намсрай (намтойсрай) бурхныг монголоор Тийн сонсогчийн хөвгүүн гэнэ. Намсрай бурхан нь найман морьт буюу найман дагуултай, том гүзээтэй, эд баялгийн бурхан юм. Намсрай бурхны эрдэнэсийн сангийн түлхүүрийг атгадаг дагуулыг Шар замбала гэдэг.

Тэмээн чинээ

Цагаан төмөр баатар гэдэг

Цамба бурхан байжээ.

Цамба бурхан гэдэг бол Энэтхэгийн домог зүйн гурван их бурхны нэг Брахмаа тэнгэр болно. Монголоор Эсрүа (Эсрүн) тэнгэр гэдэг. Цамба бурхан бол Шагжамунийг ертөнцөд залрахын цагт угтан авч, шавь орж, амьтны тусыг хязгааргүй бүтээсэн, арав дахь газрын бодисадва болно. Цамба бурхан дөрвөн зүгийг тэгш толидон харахын учир түүнийг дөрвөн талдаа нүүртэйгээр дүрсэлдэг.

Далаараа дардгар

Далан зааны хүчтэй

Хүзүүгээрээ хүгдгэр

Хүчин чадал ихтэй

Тулга шар нүдтэй

Догшин Гардийн дүртэй

Учихын мэргэн

Улаан галзуу баатар гэдэг нь

Улаан сахиус (Жамсран бурхан) байжээ.

гэснээс харахад Жангарын туулийн хамгийн зоригт баатар Араг улаан хонгорыг Улаан сахиус Жамсрантай адилтгасан нь болох нь илт байна. Жамсран сахиус бол бурханы шашны хамгийн баатарлаг хамгаалагч, диваажингийн (Сухавадийн орон) орны хаан Амитаба буюу

Авид бурхны хувилгаан болно. Тэрээр анх хамгийн догшин хөнөөлтэй тэнгэр байгаад, бурхны шашны сахиус болонгуутаа тэрсүүдийг хорлох үйлсэд хамгийн түрүүнд зарагддаг аврал нь болсон байна. Нөгөөтэйгүүр Улаан Жамсран бол монголын Автай сайн хаанаас уламжилж, найман богдоор дамжин, төр жолоодогчдын сахиус болж ирсэн бурхан юм. Монголын Ардын засгийн үед анхны долоо Орос руу мордохдоо Улаан Жамсранд мөргөөд явсан болохоор үйлс нь сайн бүтсэн гэдэг хууч яриа ч байдаг.

ДҮГНЭЛТ

1. Жангарын туулийн халх хувилбарт баатруудын тэмцэл тулаан, алаан хядаантай дайн байлдааныг төдий л дүрслэн үзүүлдэггүй бөгөөд туулийн гол үйл явдал нь бурхны шашны сүм дуган барих үйл хэрэгт төвлөрч, ар газар шашин төрийг далгарүүлж, амар сайхандаа жаргаснаар үзүүлдэг байна.
2. Жангарын туулийн халх хувилбарт үзүүлж буй орон цаг нь халимаг, ойрад Жангарын туульст гардаг нутаг тогос Алтай, өргөн шартаг далай биш, хан Богд уулын ар, хатан Туулын хөвөө, төв халхын газар нутаг болсон байна.
3. Жангарын туулийн халх хувилбарт Жангар болон түүний баатруудыг бурхны шашны домог зүйтэй холбож, шарын шашны арван хангалтай адилтган, арван хангалын хувилгаан дүр болгож дүрсэлсэн нь сонирхол татаж байна.
4. “Богд Жанхар хаан” хэмээх энэ халх хувилбар бол бурхан шашинтны буюу халхын нутагт хүрээ хийдийн газар хайлж дуулж байсан хувилбар байж болзошгүй бөгөөд аливаа домог туульс нь баларлаг эртний шинжтэй байхаас гадна өөр нийгэм, цаг үеийн дунд хэрхэн шинээр хувилбарлан хөгждөг болохын баталгаа болж байна.

HEROIC CHARACTERS IN JANGGAR EPIC AND TEN FIERCE DIVINITIES IN BUDDHISM

Many Khalkha men became lamas, almost one lama in each household, as a number of monasteries were established. Moreover, there was a common belief that everything should have religious senses, if not, that would be invaluable. One prime example is the explanation of heroic epics, especially epic of Janggar in relation to Buddhist concepts and its fierce divinities. Bogda Janghar Khaan, one version of Khalkha Janggar, is the most interesting one which has a Buddhist religious sense, noted in 1997 by Ulzii, an epic singer and daughter of Dandardorj taiji of Dashdoo gunii khoshuu, Sain Noyon Khan aimag (currently Galuut sum, Bayankhongor province)

Khalkha version of the epic Janggar describes the establishment of Buddhist monasteries, flourishing of religion and life wellness instead of aggressive heroes, and their struggles and battles.

The plot of Khalkha Janggar is depicted in the Central Khalkha, at the back of Khan Bogd Mountain and on the bank of Tuul River, not in Altai and on the sea coast which are described in Kalmyk and Oirat versions of Janggar. Bogda Janghar Khaan is said to be reincarnation of Buddha. It is interesting that characters of heroes are related to religion and mythology and depicted as ten fierce divinities of Yellow sect of Buddhism.

Khalkha versions of Janggar epic become evidence which not only show that any epic has its primitive characteristics but also how they are developed and changed throughout different

societies and time periods. It also shows that a tradition of singing epics became deed of women because most Khalha men became lamas in monasteries at that time, so it illustrates that they are different from Kalmyks and Oirats.

Номзүй

- Баясгалан Ш.** 2011. *Арван хангал бурхадын тахилга (Их Юань гүрнээс XXI зуун)*. Ариутган шүүсэн Б.Түшихбаяр. Уб.
- Богд Жанхар хаан.* Баянхонгор аймгийн Галуут сумын уугуул, үлгэрч, туульч Өлзийгээс С.Дуламын 1997 онд тэмдэглэж авсан гар бичмэл эх.
- Жангар.* 1963. Халимаг хэлнээс монгол хэлэнд Т.Дүгэрсүрэн буулгав. УХХЭХ, Уб.
- Жангарын туульс.* 1968. Удиртгал ба тайлбар сэлт үйлдэж, хэвлэлд бэлтгэсэн У.Загдсүрэн, Аман зохиол судлал. Боть VI, дэвт. 15. Уб.
- Dulam S.** 2006. *Tuuli “B jangar” dahi domuü züi-yin ögülemji*. The International Academic Symposium of Epic Jangar in Xinjiang, 10-15 Sept. 2006. Urumqi, Hebuksair, China, Abstract, p. 111-117.
- Jangyar-I.** 1988. Mongyol tulγur bicig-ün cubural. *Öbür mongyol-un arad-un keblel-ün qoriy-a.* 588
- Qalimay “Jangyar”.* 2002. A.Š.Kičikov, N.C.Bitkeyev, E.B.Ovalov emkidkebe. Ba.Damrinjab sin-e-ber emkidken, qalimay kelen-ece körbegülün tayilburilaju, tekst qarγuyulul kiged üges-ün tayilburi kibe. *Ündüsün-ü keblel-ün qoriy-a.*